



Some Results of the 2025 Activities of the Joint Mongolian–Russian Search Expedition Conducted at the Khalkhin Gol Battlefield

Tsetsegmaa Byamba-Erdene¹, Oyunjargal Battulga², G.Ganzorig³,
Enkhbat Ochkhuu⁴

¹Research Fellow, Center for Military History Studies, Defense Research Institute of Mongolia,
E-mail address: byamba-erdene@mids.gov.mn, ORCID: [0009-0001-7512-8346](https://orcid.org/0009-0001-7512-8346)

²Senior Forensic Expert at the Document Examination Laboratory, Criminalistics Department,
National Forensic Agency of Mongolia, Police Major; E-mail address: battulga8000@gmail.com

³Ganzorig. G, Department of Engineering and Technical Forensic Digital forensic laboratory,
National forensic Agency of Mongolia

⁴Ph.D., Senior Research Fellow, Center for Military History Studies, Defense Research Institute
of Mongolia, E-mail address: Ochkhuu1025@gmail.com

Received: 11 June 2026

Revised: 23 June 2026

Accepted: 26 June 2026

Published online: 28 July 2026



ABSTRACT

Within the framework of the agreement between the Presidents of Mongolia and the Russian Federation on jointly commemorating the 80th anniversary of the Victory in the Liberation War, a Mongolian–Russian joint search and recovery expedition was conducted on the battlefield of the Khalkhin Gol (Nomonhan) War in May and September 2025. The primary objective of the expedition was to locate, identify, and respectfully rebury the remains of soldiers who were killed in action or reported missing during the conflict, as well as to preserve and commemorate their historical legacy.

The research employed a multidisciplinary methodology, including archaeological survey and excavation, forensic anthropology, firearms analysis, and comparative examination of historical archival sources. During an eight-day field season in May 2025, excavations were carried out at 138 locations, resulting in the recovery of the remains of 49 soldiers, 294 items of unexploded ordnance, more than 3,000 rounds of ammunition, and 72 artifacts of significant museum value.

A second phase of fieldwork was conducted in September 2025 in the areas of Remizov Heights, Bayantsagaan Ridge, Khuruu Heights, and Khilchin Heights (also known as Green Hill), as well as at locations identified through archival research. Surveys were undertaken across approximately 15.5 km² using metal detectors and probing techniques to investigate defensive structures, trenches, elevated positions, and other battlefield features. Over a ten-day period, excavations were conducted at 93 locations, leading to the discovery of the remains of 68 Russian and 18 Japanese soldiers, 209 pieces of unexploded ordnance representing ten different types, more than 3,000 rounds of small-arms ammunition, approximately 6 m³ of battlefield debris, and 174 artifacts representing 38 categories suitable for display in both field and indoor museum exhibitions.

Anthropological analysis of the recovered skeletal remains enabled the determination of age, sex, stature, and anthropological characteristics. Furthermore, the examination of associated artifacts

provided valuable information regarding the military affiliation of the soldiers and the circumstances of combat in which they perished.

The findings contribute new empirical evidence to the history of the Khalkhin Gol Battle while also demonstrating the value of military archaeology and forensic anthropology as important tools for the investigation and interpretation of twentieth-century battlefields.

Keywords: Khalkhin Gol War, military archaeology, forensic anthropology, soldiers' remains, artifacts, 3D scanning, Arisaka rifle.

Халхын голын байлдааны талбарт ажилласан Монгол Улс, Оросын холбооны улсын хамтарсан эрэл хайгуулын экспедицийн 2025 оны ажлын зарим үр дүнгээс

Ц.Бямба-Эрдэнэ¹, О.Баттулга², Г.Ганзориг³, Э.Очхүү⁴

¹Батлан Хамгаалахын Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр, ахмад, byamba-erdene@mids.gov.mn,
ORCID: 0009-0001-7512-8346

²Шүүх Шинжилгээний Ерөнхий Газар Криминалистикийн шинжилгээний газрын Криминалистикийн шинжилгээний хэлтсийн Бичиг баримтын шинжилгээний лабораторийн ахлах шинжээч, цагдаагийн хошууч, battulga8000@gmail.com

³Шүүх Шинжилгээний Ерөнхий Газар Инженер-техникийн шинжилгээний газрын Цахим технологийн шинжилгээний лабораторийн эрхлэгч, цагдаагийн хошууч

⁴Батлан Хамгаалахын Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), хошууч, Ochkhui1025@gmail.com

ХУРААНГУЙ

Монгол Улс, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нарын “Чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ойг хамтран тэмдэглэх тухай” тохиролцооны хүрээнд Халх голын дайны талбарт Монгол-Оросын хамтарсан эрэл хайгуулын экспедиц 2025 оны 5 болон 9 дүгээр саруудад ажиллав. Экспедицийн зорилго нь дайны үеэр амь үрэгдсэн болон сураггүй алга болсон дайчдын шарил, үлдэц (цогцос)-ийг илрүүлэх, тодорхойлох, хүндэтгэлтэйгээр оршуулах, түүхэн дурсгалыг мөнхжүүлэхэд оршиж байв. Судалгааны явцад археологийн хайгуул, малтлага, шүүх антропологи, галт зэвсэг судлал, түүхэн эх сурвалжийн харьцуулсан шинжилгээ зэрэг олон талт арга зүйг ашиглалаа. 2025 оны 5 дугаар сард найман өдрийн хугацаанд нийт 138 цэгт малтлага хийж, 49 дайчны шарил болон үлдэгдэл, тэсэрч дэлбэрээгүй 294 ширхэг галт хэрэгслэл, 3000 гаруй сум, музейн үзмэрийн ач холбогдол бүхий 72 эд өлгийн зүйл илрүүлсэн бол 2025 оны 9 дүгээр сард Хайгуул малтлагын ажлыг “Ремизов”-ын өндөрлөг, “Баянцагааны нуруу”, “Хуруу өндөр”, “Хилчин өндөр буюу Ногоон толгой”-ийн районууд болон архивын баримт бичгийн эх сурвалжид тулгуурласан болон газар орны хөрсний сорив бэхлэлт, шуудуу, траншей, өндөрлөг зэрэг нийт 15.5км² талбай, хэсэгт металл хайгч, газрын шөвгийн тусламжтайгаар хайгуул явуулснаар 10 өдрийн дотор 93 цэгт малтлага хийж, 68 орос, 18 япон цэргийн шарил, түүний үлдэц мөн 10 төрлийн 209 ширхэг тэсрээгүй галт хэрэгслэл, буудлагын зэвсгийн 3000 гаруй сум, бусад 6м3 хог хаягдал, 38 нэр төрлийн 174 ширхэг хээрийн болон заалны музейд байрлуулж болох эд зүйлс, үзмэрийг илрүүлсэн (Ц.Бямба-Эрдэнэ 2025).

Илэрсэн хүний араг ясанд хүйсэн шинжилгээгээр нас, хүйс, биеийн өндөр болон антропологийн хэв шинжийг тогтоосон бөгөөд зарим шарилтай холбоотой эд өлгийн зүйлсийн шинжилгээгээр дайчдын харьяалал, байлдааны нөхцөл байдлыг тодруулах боломж бүрсэн. Судалгааны үр дүн нь Халх голын байлдааны түүхийг баримтаар баяжуулахын зэрэгцээ цэргийн археологи, шүүх антропологийн судалгааны шинэ хэрэглээг хөгжүүлэхэд ач холбогдолтой байна.

Түлхүүр үгс: Халх голын дайн, цэргийн археологи, шүүх антропологи, дайчны шарил, эд өлгийн

зүйл, 3D сканнер, Arisaka винтов.

Оршил

Халх голын дайн нь Монгол Улсын тусгаар тогтнол, Зүүн хойд Азийн геополитикийн нөхцөл байдалд онцгой нөлөө үзүүлсэн XX зууны томоохон дайны нэг юм. Энэхүү дайны талбарт өнөөг хүртэл илрээгүй үлдсэн дайчдын шарил, эд өлгийн зүйлс нь зөвхөн түүхэн төдийгүй шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой судалгааны объект болсоор байна. Энэ удаад бид тус экспедицийн хүрээнд илрүүлсэн 5 хүн (Монгол)-ий шарил, эд өлгийн зүйлсэд хийсэн шүүх антропологи болон цэргийн археологийн судалгааны зарим үр дүнг танилцуулахад оршино.

Монгол Улс, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нарын “Чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ойг хамтран тэмдэглэх тухай” 2024 оны яриа хэлэлцээрийн хүрээнд “Халх голын дайны талбарт амь үрэгдэн, сураггүй алга болсон дайчдын шарил, түүний үлдцийг илрүүлэх, хэн болохыг нь тодорхойлох, албан ёсоор хүндэтгэлтэйгээр оршуулах, мөнхжүүлэх үйл ажиллагааг шат дараатайгаар хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улс, Оросын Холбооны Улсын хамтарсан эрэл хайгуулын экспедиц Халхын голын дайны талбарт 2025 оны 5, 9 дүгээр сард ажиллалаа. Тус экспедицийн бүрэлдэхүүнд Монгол Улсын талаас Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Дотоод хэргийн их сургууль, Хилийн цэргийн Хил судлалын хүрээлэн, Монгол цэргийн музей, Зэвсэгт хүчний 011, 016, 089, 186, 284, 327 дугаар ангиас тодорхой тооны бүрэлдэхүүн, Оросын Холбооны Улсын талаас ОХУ-ын Засгийн газрын дэргэдэх Эдийн засгийн их сургуулийн Археологийн судалгааны төв болон сайн дурын хүмүүс ажиллав (Ц.Бямба-Эрдэнэ, Э.Очхүү 2025).

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Хил хамгаалах ерөнхий газрын Хил судлалын хүрээлэнтэй хамтран Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Батлан хамгаалах яамны дэмжлэгээр “Цэргийн археологи” эрдэм шинжилгээний ажлыг 2024 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1-д тусгасан “Халх голын бүс нутгийн түүхэн дурсгалт газар, барилга байгууламжийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах ажлыг зохион байгуулах, цэргийн түүх, археологийн судалгааг хөгжүүлэх, Халхын голын музейн үзмэр, сан хөмрөгийг баяжуулах, эх орончдын парк болгох ажлыг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх” заалтуудыг үндэслэл болгон Халх голын байлдааны талбарт археологийн судалгааг үе шаттай явуулсан (Н.Эрдэнэ-Очир, Ц.Бямба-Эрдэнэ, С.Далантай, Э.Түвшин 2024) байна.

Тус шинжилгээний анги “Халх голын байлдааны ялалтын түүхт 85 жил”-ийн ойг тохиолдуулан мэргэжлийн байгууллагууд хамтран цэргийн археологийг Соёлын яамны зохих зөвшөөрлийн хүрээнд хийж гүйцэтгэхдээ шугаман хайгуул, малтлага судалгааг шинэ дэвшилтэд технологи нисдэг төхөөрөмжийн тусламжтай агаараас тандах аргачлалтай хослуулан сорьцын цооног малтах, металл хайгч ашиглах, тухайлан сонгосон газарт нарийвчилсан хайгуул хийжээ (Н.Эрдэнэ-Очир, Ц.Бямба-Эрдэнэ, С.Далантай, Э.Түвшин 2024).

2025 оны 5 дугаар сард найман өдрийн хугацаанд нийт 138 цэгт малтлага хийж, 49 дайчны шарил болон үлдэгдэл, тэсэрч дэлбэрээгүй 294 ширхэг галт хэрэглэл,

3000 гаруй сум, музейн үзмэрийн ач холбогдол бүхий 72 эд өлгийн зүйл илрүүлсэн бол 2025 оны 9 дүгээр сард Хайгуул малтлагын ажлыг “Ремизов”-ын өндөрлөг, “Баянцагааны нуруу”, “Хуруу өндөр”, “Хилчин өндөрлөг, Ногоон өндөрлөг зэрэг газруудад болон архивын баримт бичгийн эх сурвалжид тулгуурласан газар орны хөрсний сорив бэхлэлт, шуудуу, траншей, өндөрлөг зэрэг нийт 15.5км² талбай, хэсэгт металл хайгч, газрын шөвгийн тусламжтайгаар хайгуул явуулснаар 10 өдрийн дотор 93 цэгт малтлага хийж, 68 орос, 18 япон цэргийн шарил, түүний үлдэц мөн 10 төрлийн 209 ширхэг тэсрээгүй галт хэрэглэл, буудлагын зэвсгийн 3000 гаруй сум, бусад 6м³ хог хаягдал, 38 нэр төрлийн 174 ширхэг эд зүйлс илрүүллээ.

Тухайн бүс нутагт байгалийн жамаар болон хүний оролцоотойгоор тэсэрч дэлбэрэх галт хэрэглэл ил гарч ирэх, аюул учруулах эрсдэл өндөр бөгөөд илэрснийг нь урьд өмнө ямар нэгэн зохион байгуулалтгүй бүлэг, баг, хувь хүн, иргэд дуртай газраа хамаагүй хаяж явдаг зэрэг асуудлууд гардагтай холбогдуулан орон нутгийн иргэд тус ажил арга хэмжээг эерэг бус сөрөг талыг илүүтэй хөндөх байдал хамтарсан хайгуулын экспедицийн ажлын эхэн үед нэг бус байдлаар илэрхийлсэн. Тиймээс эерэг нөхцөлийг бий болгох зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр хайгуулын ажлын явцын талаарх мэдээллийг шуурхай мэдээлэх, тухайн газар оронд цаг хугацааны хувьд зохимжид байдлыг ашиглан мод тарих, илэрсэн тэсэрч дэлбэрээгүй галт хэрэглэлийг орон нутгийн иргэд, удирдлагын хяналт дор устгах зэргээс гадна хайгуул хийсэн талбайд цэвэрлэгээ хийх, хөшөө дурсгалын орчныг сэргээн сайжруулах зэргээр цогц зохион байгуулалттай арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

Хайгуулын хамтарсан экспедиц ажиллах талбайд Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн тэсэрч дэлбэрэх зүйлийн хайгуул устгалын бүлэг урьдчилан самналт, хайлт үзлэг явуулж аюулгүй болгох арга хэмжээг авч, аюулгүй байдлыг хангасан хэдий ч тухайн газар орноос малтлагын явцад чагт нь мултраагүй гар гранат, тэсрүүлэгч холбогдсон миномётын мин илэрсээр байгаа тул аюулгүй байдлыг хангаж ажиллах шаардлага алхам тутамд тулгарч байв.

Судалгааны аргазүй

Энэхүү судалгаанд цэргийн археологи, шүүх антропологи, галт зэвсэг судлал, түүхэн эх сурвалжийн шинжилгээний нэгдмэл арга зүйг ашиглав. Хээрийн судалгааг 2025 оны 5 болон 9 дүгээр сард Халх голын байлдааны талбарын “Ремизовын өндөрлөг”, “Баянцагааны нуруу”, “Хуруу өндөр”, Хилчин өндөрлөг, Ногоон өндөрлөг зэрэг стратегийн ач холбогдол бүхий бүсэд гүйцэтгэсэн.

Археологийн хайгуулын ажлын хүрээнд архивын баримт бичиг, байлдааны газрын зураг, өмнөх судалгааны үр дүнгүүдэд тулгуурлан судалгааны талбайг сонгосон. Хайгуулын үед нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр агаараас тандалт хийх, металл хайгч болон газрын шөвөг ашиглан илрүүлэлт явуулах, сорьцын цооног малтах, шугаман малтлага хийх зэрэг аргыг хослуулан хэрэглэв.

Хээрийн судалгааны явцад илрүүлсэн Монгол цэргийн байх магадлалтай гэж үзсэн 5 шарил, үлдэгдлийг баримтжуулж, дугаарлан савлаж Шүүх шинжилгээний ерөнхий газрын лабораторийн шинжилгээнд шилжүүлсэн. Шүүх антропологийн шинжилгээнд гавал яс, аарцаг яс, урт мөчдийн ясанд хэмжилт, ажиглалт хийж

биологийн нас, хүйс, биеийн өндрийг тодорхойлов. Нас тогтоохдоо гавлын ясны заадлын нийлэгжилт, агт араа шүдний ургалт, шүдний элэгдлийн зэрэглэлд тулгуурласан бол хүйс тогтоохдоо аарцаг яс болон гавлын ясны морфологийн шинжүүдийг ашиглав.

Мөн илэрсэн эд өлгийн зүйлсэд сэргээн засварлалт, галт зэвсгийн шинжилгээ, бичиг баримт сэргээн унших шинжилгээ хийж, эд зүйлсийн зориулалт, гарал үүсэл, он цагийг тодорхойлохыг зорьсон. Зарим гавал ясыг 3 хэмжээст сканнер ашиглан цахим загварт оруулж, нүүр царай сэргээн дүрслэх судалгааны суурь мэдээллийг бүрдүүлэв.

Судалгааны үр дүн

Шүүх антропологийн шинжилгээний үр дүн

2025 оны 5 дугаар сард илрүүлсэн таван хүний араг ясанд хийсэн шинжилгээгээр бүгд эрэгтэй хүйстэй болох нь тогтоогдов. Нас, биеийн өндрийн үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв.

Дээж	Нас (жил)	Өндөр (см)	Хүйс
24/1	24–27	160–165	Эрэгтэй
24/2	30–35	165–170	Эрэгтэй
36/1	40–45	160–165	Эрэгтэй
36/2	35–40	162–167	Эрэгтэй
36/3	18–23	169–174	Эрэгтэй

Бүх сорьцод монголжуу антропологийн хэв шинж давамгайл илэрсэн. Гэсэн хэдий ч үндэс угсааг зөвхөн морфологийн шинжээр эцэслэн тогтоох боломжгүй тул цаашид молекул генетикийн судалгаа хийх шаардлагатай байна ([Г.Ганзориг 2025](#)).

Эд өлгийн зүйлсийн судалгааны үр дүн

Судалгаагаар илэрсэн 36/2 дугаартай шарилтай холбоотойгоор илэрсэн хоёр сумны хошуунд хийсэн шинжилгээгээр нэг нь Японы Arisaka-38 загварын винтов буунд хэрэглэгддэг 6.5×50 мм, нөгөө нь Arisaka-92 загварын пулемётын 7.7×58 мм сум болох нь тогтоогдов. (Зураг 1-6)

Мөн зургаан хэсэг болон задарсан цаасан баримтыг сэргээн нэгтгэж, тусгай программ ашиглан боловсруулсны дүнд 1939 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Улаан одон” сонины №56 дугаарын хэсэг болохыг тогтоосон. (Зураг 7-9)

Судалгаагаар илэрсэн 36/3 дугаартай араг ясны хоёр болон гуравдугаар сээр нугалмын хооронд Arisaka-38 винтовын сумны хошуу илэрсэн нь тухайн хүний амь нас хөнөөгдөхөд буудлагын шарх нөлөөлсөн байх магадлалтайг харуулж байна. (Зураг 10-12)

Үүнээс гадна шүдний сойз, зоос, дүрэмт хувцасны товч, тэмдэг, арьсан болон даавуун эдлэлийн үлдэгдэл илэрсэн бөгөөд эдгээр нь тухайн үеийн дайчдын өдөр тутмын хэрэглээ, цэргийн бэлтгэлийн талаар мэдээлэл өгч байна.

3 хэмжээст дүрслэлийн үр дүн

Судалгаагаар илэрсэн 24/1 дугаартай гавал ясыг 3 хэмжээст сканнер ашиглан цахим хэлбэрт шилжүүлж, 3D хэвлэгчээр загвар бүтээв (Зураг 13-15). Энэхүү технологи нь гавал ясны хэмжилтийг өндөр нарийвчлалтай хийх, нүүр царай сэргээн дүрслэх, судалгааны өгөгдлийг урт хугацаанд хадгалах давуу талтай болох нь батлагдав.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Халх голын байлдааны талбарт хийсэн энэхүү судалгаа нь Монгол Улсад харьцангуй шинэ чиглэл болох цэргийн археологи болон шүүх антропологийн хамтарсан судалгааны ач холбогдлыг харуулж байна. Судалгааны үр дүнд илэрсэн хүний шарил, эд өлгийн зүйлс нь байлдааны түүхийг зөвхөн архивын баримт, дурсамжид тулгуурлан бус, бодит материаллаг эх хэрэглэгдэхүүнээр баталгаажуулах боломжийг бүрдүүлэв.

Антропологийн шинжилгээгээр судлагдсан таван тохиолдол бүгд эрэгтэй, 18–45 насны хооронд байсан нь тухайн үеийн цэргийн алба хаагчдын насны бүтэцтэй нийцэж байна. Илэрсэн араг яснуудын хадгалалтын түвшин харилцан адилгүй байсан бөгөөд хөрсний хүчиллэг орчин, цаг уурын нөхцөл, ургамлын үндэсний нөлөө зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан зарим яс бүрэн бус хадгалагдсан байв. Энэ нь нас, хүйс, биеийн жинг тодорхойлох боломжийг тодорхой хэмжээгээр хязгаарлаж байна.

Судалгаагаар илэрсэн 36/3 дугаартай шарилын сээр нугалмын сувагт илэрсэн сумны хошуу нь тухайн хүний нас баралтын шалтгааныг тодорхойлох чухал нотлох баримт болж байна. Галт зэвсгийн шинжилгээгээр уг сум нь Япон улсын Arisaka-38 загварын винтовын 6.5×50 мм сум болох нь тогтоогдсон нь байлдааны үеийн шархталын шинж чанарыг сэргээн тодорхойлох боломжийг олгож байна.

Эд өлгийн зүйлсийн судалгаагаар илэрсэн “Готов к ПВХО” тэмдэг, дүрэмт хувцасны товч, шүдний сойз, зоос зэрэг олдворууд нь тухайн цэргийн алба хаагчдын өдөр тутмын амьдрал, сургалт бэлтгэл, нийгэм-соёлын орчны талаар мэдээлэл өгч байна. Түүнчлэн 1939 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Улаан одон” сонины хэсгийг сэргээн тодорхойлсон нь тухайн шарилын он цаг, түүхэн нөхцөл байдлыг тогтооход нэмэлт нотолгоо болж байна.

Энэхүү судалгаанд 3 хэмжээст сканнерын технологийг ашигласан нь шүүх шинжилгээний практикт шинэ боломжийг нээж байна. Гавал ясыг дижитал орчинд загварчилснаар хэмжилтийн нарийвчлалыг сайжруулах, нүүр царай сэргээн дүрслэх, өгөгдлийг урт хугацаанд хадгалах нөхцөл бүрдэж байна. Цаашид энэхүү технологийг ДНХ шинжилгээ, гео-мэдээллийн систем, фотограмметрийн аргуудтай уялдуулан ашиглах нь судалгааны үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой.

Судалгааны үр дүнгээс харахад Халх голын байлдааны талбар нь цэргийн археологийн өндөр ач холбогдолтой өвийн бүс нутаг бөгөөд цаашид системтэй, урт хугацааны судалгааг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд үргэлжлүүлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улс, Оросын Холбооны Улсын хамтарсан эрэл хайгуулын экспедицийн хүрээнд Халх голын байлдааны талбарт 2025 онд хэрэгжүүлсэн археологи, шүүх

антропологийн судалгаагаар дараах үндсэн үр дүнгүүдийг гаргав.

Нэгдүгээрт, байлдааны талбарт нийт 135 дайчны шарил, үлдэгдэл илрүүлэн баримтжуулж, түүхэн үнэ цэнтэй олон тооны эд өлгийн зүйлсийг бүртгэн авсан нь Халх голын дайны бодит түүхийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр сэргээн судлах боломжийг өргөжүүлэв.

Хоёрдугаарт, судалгаагаар илэрсэн монгол цэргийн байх магадлалтай 5 хүний араг ясанд хийсэн антропологийн шинжилгээгээр нас, хүйс, биеийн өндрийн үзүүлэлтүүдийг тогтоож, шарилуудын биологийн онцлогийг тодорхойлов.

Гуравдугаарт, сумны хошуу, цэргийн тэмдэг, хэвлэл мэдээллийн эх сурвалж зэрэг олдворуудыг шинжилснээр тухайн үеийн байлдааны нөхцөл байдал, цэргийн хэрэглээ, алба хаагчдын өдөр тутмын амьдралын талаар шинэ мэдээлэл цуглуулав.

Дөрөвдүгээрт, гавал ясны 3 хэмжээст сканнерчлал, дижитал загварчлалыг амжилттай хэрэгжүүлсэн нь хүний төрх сэргээн дүрслэх болон шүүх шинжилгээний орчин үеийн аргыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг харуулав.

Иймд цаашид илэрсэн шарилуудад молекул генетикийн болон изотопын шинжилгээ хийх, дижитал өгөгдлийн сан бүрдүүлэх, Халх голын байлдааны өвийг хамгаалах, судлах ажлыг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд үргэлжлүүлэн хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн Батлан хамгаалах яам, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Шүүх шинжилгээний ерөнхий газар, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Хил хамгаалах ерөнхий газрын Хил судлалын хүрээлэн, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Монгол цэргийн музей, Монгол-Оросын хамтарсан эрэл хайгуулын экспедицийн нийт бүрэлдэхүүнд талархал илэрхийлье.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Г.Ганзориг. 2025. ““Халхын голын байлдааны талбар дахь Монгол Улс, Оросын холбооны улсын хамтарсан хайгуулын экспедицийн ирүүлсэн Монгол гэх таван араг яс”-нд хэмжилт судалгаа хийсэн тухай илтгэх хуудас.” Илтгэх хуудас.
2. Н.Эрдэнэ-Очир, Ц.Бямба-Эрдэнэ, С.Далантай, Э.Түвшин. 2024. ““Цэргийн археологи” төслийн тайлан.” Улаанбаатар.
3. Ц.Бямба-Эрдэнэ. 2025. “Халх голын байлдааны талбар дахь Монгол Улс, Оросын холбооны улсын хамтарсан хайгуулын экспедицийн үйл ажиллагааг зохион байгуулж явуулсан тухай тайлан.” Улаанбаатар.
4. Ц.Бямба-Эрдэнэ, Э.Очхүү. 2025. “Халхын голын дайны талбарт ажилласан тайлан.” Улаанбаатар.

ХАВСРАЛТ



Зураг 1. 36/2 дугаартай уутанд байсан сумны хошуу



Зураг 2. Тухайн сумны төрөл загвар



Зураг 3. Arisaka-38 загварын винтов буу



Зураг 4. 36/2 дугаартай уутанд байсан сумны хошуу



Зураг 5. Тухайн сумны төрөл загвар




Зураг 6. Arisaka-92 загварын пулемёт буу



Зураг 7. Нэг бүхэл болсон цаасны хэсэг




**Зураг 8. Уншигдах боломжтой
болгож тодруулсан байдал**



Зураг 9. 1939-05-10-ний өдрийн “Улаан одон” сонины №56 дугаарын хэсгээс



Зураг 10-12. Нугасны сүвэнд байсан сумны хошуу, түүний загварыг харуулав.



Зураг 13-15. Малтлагаар 24/1 гэж дугаарласан гавал ясыг 3D орчинд дүрсэлж, 3D принтерээр хэвлэсэн байгааг харуулав.